



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2001 оны 01 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 16.

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх, ажилд томилох,
дүрэм, орон тоог батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, "Статистикийн тухай хууль"-ийн 15 дугаар зүйл, Үндэсний статистикийн газрын даргын 1997 оны 81 тоот тушаал, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Бүтцийг шинэчлэн тогтоож байгаатай холбогдуулан Ч.Баянчимэгийг нийслэлийн Засаг даргын Статистик, мэдээлэл, судалгааны албаны даргын үүрэгт ажлаас 2000 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

Хоёр. Статистик, мэдээлэл, судалгааны газрын даргаар Чилхаасүрэнгийн Баянчимэгийг 2001 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн томилж, сарын үндсэн цалинг 70445 төгрөгөөр /ТЗ-10/, нэмэгдлийг 45 хувиар тогтоосугай.

Гурав. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Статистик, мэдээлэл, судалгааны газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.


Дөрөв. Статистик, мэдээлэл, судалгааны газрыг "Иргэдэд мэдээллээр үйлчлэх төв"-тэй, орон тооны хязгаарыг 14 хүртэл байхаар тогтоосугай.

Тав. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөж ажиллахыг Статистик, мэдээлэл, судалгааны газар /Ч.Баянчимэг/-т даалгасугай.

Зургаа. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/18, Б/77, Б/182, Б/219 дүгээр захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ


М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2001 оны
168 дугаар захирамжийн хавсралт

СТАТИСТИК, МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Статистик, мэдээлэл судалгааны газар /цаашид "газар" гэх/ нь нийслэлийн Засаг даргын статистикийн талаарх бүрэн эрхийг нийслэлд хэрэгжүүлэх, нийгмийн судалгаа хийх үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Статистикийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын мөрийн хөтөлбөр, захирамж, Үндэсний статистикийн газрын даргын шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газар, Үндэсний статистикийн газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4. Газрын даргыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санал болгосноор Үндэсний статистикийн газрын дарга томилж, чөлөөлнө.

1.5. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, нийслэлийн төсвөөс үйл ажиллагааг нь санхүүжүүлнэ.

ИЗД-ын 2002 оны 124-р захирамжаар хүчингүй

1.6. Газар нь иргэдэд мэдээллээр үйлчлэх төвтэй байна.

1.7. Газрын дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

1.8. Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан газрын албан хаагчдыг томилж, чөлөөлнө. Иргэдэд мэдээллээр үйлчлэх төвийн эрхлэгчийг нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр томилж, чөлөөлнө.

1.9. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.10. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батлана.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Газар нь Монгол улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2. Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3. Монгол улсын Статистикийн тухай хуулийн дагуу нийслэлийн Засаг даргын статистикийн мэдээллийн талаарх бүрэн эрхийг нийслэлийн нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлж, статистикийн бүртгэл хөтлөх, мэдээлэл гаргаж өгөх, дамжуулах, нэгтгэн боловсруулах, тооллого судалгаа явуулах, дүгнэлт гаргах, мэдээлэл судалгааны үр дүнг хэрэглэгчдэд тараах, хэвлэн нийтлэх, мэдээллийн үнэн зөв байдлыг хангах, мэдээллийн сан байгуулах, хадгалах, тоо материалыг хянаж баталгаа өгөх зэрэг статистикийн үйл ажиллагааг явуулах.

2.4. Дотоодын нийт бүтээгдэхүүн, хүн ам зүй, хөдөлмөрийн нөөц, хүн амын мөнгөн орлого, зарлага, амьжиргааны түвшин, үндэсний баялгийн тэнцэл боловсруулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэн тооцох.

2.5. Нийслэлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн өсөлт, өөрчлөлттэй холбогдолтой статистикийн тоо материалд тулгуурлан эдийн засгийн тойм, богино хугацааны прогноз боловсруулах.

2.6. Статистикийн мэдээ тайлан, бүртгэл, судалгааны талаар гарсан тогтоол шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, түүний биелэлтэд хяналт тавих, энэ талаар нийслэлийн Засаг даргад асуудал оруулж шийдвэрлүүлэх.

2.7. Нийслэлийн эдийн засаг, байгаль, нийгмийн холбогдолтой нэгдсэн болон салбарын мэдээллийн сангуудыг бий болгож баяжуулах, төсөл, программ хангамжийг боловсруулан нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төр, захиргааны байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулан ашиглах.

2.8. Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын мэдээлэл боловсруулалтын ажилд шаардлагатай техник хэрэгслэлийг сонгон захиалахад санал өгөх, тэдгээрийг суурилуулах, шинэчлэх ажлыг боловсруулан хэрэгжүүлэх, нэвтрүүлэхэд туслах.

2.9. Нийслэлийн төр захиргааны байгууллагуудын мэдээллийн дотоод болон нэгдсэн сүлжээ, мэдээллийн сангийн хамрах хүрээ, мэдээллийн урсгал давтамжийг тогтоох, тасралтгүй ажиллагааг хангах, эдгээр сүлжээг ажиллуулах, ашиглах журмыг боловсруулж мөрдүүлэх, хяналт тавих.

2.10. Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг шинээр бий болох, өөрчлөгдөх буюу татан буугдахад бүртгэлийн дугаарыг /регистр/ олгох, өөрчлөх, хасах.

2.11. Нийслэлийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагааны талаар нийгмийн судалгааг зохион байгуулах, дүнг нэгтгэн танилцуулах.

2.12. Дүүргийн статистикийн албадыг мэргэжлийн удирдлагаар хангах, тэдний мэргэжил, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх.

2.13. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

2.14. Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

2.15. Эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох зайлшгүй шаардлагатай асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

Гурав. Газрын эрх

3.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа статистикийн мэдээлэгчдээс статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргуулан авч нэгтгэх, судалгаа дүгнэлт хийж ашиглах, албан ёсны статистикийн мэдээллийг хугацаанд нь зохих шатны байгууллагад өгөх.

3.2. Харъяа байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилох, томилоход санал өгөх, тэдний ажлын талаар санал дүгнэлт гаргах.

3.3. Харъяа байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, тэдгээрийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт оруулж шийдвэрлүүлэх.

3.4. Харъяа байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилт, төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, газрын батлагдсан төсвийг захиран зарцуулж тайлагнах.

3.5. Албан ёсны статистик мэдээллийн үнэн зөв байдалд тогтмол шалгалт хийж, түүний бодит байдлыг хангах.

3.6. Статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд газар дээр нь очиж гаргуулан авах, гарсан зардлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх.

3.7. Мэдээлэл, судалгааны дүнг хэвлэл, мэдээллийн хэрэгслэлээр нийтэд хүргэх.

3.8. Үндэсний статистикийн газраас өгсөн удирдамж, чиглэлийн дагуу статистикийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах.

3.9. Нийслэлийн удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэх зорилгоор албан ёсны статистикийн мэдээллийг бусад мэдээлэлтэй давхардуулахгүйгээр статистикийн байгууллагын зөвшөөрснөөр авах, мэдээллийн санг бий болгох.

3.10. Үндэсний статистикийн газар болон бусад төрийн байгууллагаас боловсруулсан бүртгэл, мэдээ тайлангийн аргачлал, заавар, маягтыг боловсронгуй болгох саналаа тавих.

3.11. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.12. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль, тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.

-----oO-----